

**УУЛ УУЛХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРЛЭЛ, АЧАА ТЭЭВРИЙН ЧИГЛЭЛЭЭР
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛЖ БУЙ АЖ АХУЙ НЭГЖИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ**

2020 оны 11 дүгээр
сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

- Хүн хоорондын зайг гадаад орчин болон ажлын байранд чанд мөрдөх, амны хаалтыг зөв, тогтмол хэрэглэж хэвших,
- Нийтийн байранд үйлдвэрийн ажилтны ээлжийг холилдуулахгүйгээр зохицуулалт хийж, халдвар хүн амын дунд тархах эрсдлийг бууруулах,
- Халуун хэмжих төхөөрөмж, гар халдваргүйжүүлэгчийг гадна орох хаалганы дотор талд хүн олноор зорчдог хэсэг бүрийн хаалганы ойролцоо байршуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах,
- Эмч, эмнэлгийн мэргэжилтэн бүрт халдварын сэргийлэлт хяналт, сорьц авах, хадгалах, тээвэрлэх арга зүй, оношилгоо эмчилгээний заавар журмыг танилцуулж, сургалтад хамруулах,
- Түр тусгаарлах өрөөг бэлдэх, бэлэн байдлыг хангах,
- Ажилтан, ажиллагсдыг түргэвчилсэн оношлуур болон ПСР хийх шинжилгээнд хамруулах, Олон хүнтэй харьцдаг үйлчилгээний ажилтан, хоолны газрын тогооч, үйлчлэгчид, ээлжийн ахлагч зэрэг мэргэжлийн ажилтнуудыг эхний ээлжинд шинжилгээнд хамруулах,
- Жолооч нарыг хувийн хамгаалах хувцас (амны хаалт, ажлын болон нэг удаагийн хувцас, бээлий зэрэг) хэрэгслээр хангах,
- Хувийн хамгаалах хувцас хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодисын 1 сараас доошгүй хугацааны нөөцийг бүрдүүлэх,
- Жолооч нарт КОВИД-19-тай тэмцэх чиглэлээр мэдээлэл сурталчилгааг тогтмол хүргэх,
- Эд зүйлсийг бусадтай хуваалцаж, сольж хэрэглэхгүй байх (утас, ширээ, цаас, ажлын хэрэгсэл, бэлэн мөнгө)
- Зорчих хэсгийн урсгалыг нэг чиглэлд болгох зохицуулалт хийх,
- Гадаа бие засах газартай бол сэжигтэй хүн, эрүүл хүн нэг жорлон ашиглахгүй байх боломжийг бүрдүүлэх,
- Ажилтан, ажиллагсдын гэр бүлийг түргэвчилсэн оношлуур болон ПСР хийх шинжилгээнд хамруулах, шинжилгээгүйгээр уурхайн ажилтнуудтай өдөр тутам харьцдаг урсгалыг зогсоох,
- Ажилтан, ажиллагсдын дэлгэрэнгүй судалгаа (бага насны хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, жирэмсэн эмэгтэй, төрсөн эх, өндөр настан, архаг хууч өвчтэй)-г гаргаж, дархлаа дэмжих бүтээгдэхүүнээр хангах, хөдөлмөрийн зохицуулалт хийх,

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

AlbanBichig-4